

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 27.180

Салхин ус өргүүр. Техникийн шаардлага	MNS 5066 : 2001
Wind pump. Technical specification	

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2001 оны 09-р сарын 27-ны өдрийн 53 тоот тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2001 оны 11-р сарын 01-ээс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

## 0 Удиртгал

Монгол орны нутаг дэвсгэрийн I, II, III, IV бүсэд салхин ус өргүүрийг ашиглах бололцоотой бөгөөд уг бүсэд ашиглах эдийн засгийн тооцоонд салхины дундаж хурдыг сонгон авч ашиглана. Салхины эрчим хүчний нөөцийн тархалтын зургийг үз. ( А хавсралт ) Салхин ус өргүүрийг суурилуулах газрыг зөв сонгож авах нь эдийн засгийн чухал ач холбогдолтой.

## 1 Хамрах ба хэрэглэх хүрээ

Энэхүү стандарт нь салхины эрчим хүчийг ашиглан худгаас ус татах зориулалттай салхин ус өргүүрт тавигдах техникийн шаардлагыг тогтооно.

Энэ стандарт нь тусгай зориулалтын салхин төхөөрөмжүүдэд хамаарахгүй.

## 2 Салхин ус өргүүрийн иж бүрдэл

2.1. Усны шахуурга, ус өргөх яндан, уян гол, шахуургыг гараар ажиллуулах хөшүүрэг, нягтруулагч, салхи хэмжигч, яндангийн түлхүүр, муфт, эрээс гаргагч багажаар тоноглогдсон байна.

## 3 Нэр томъёо, тодорхойлолт

Салхины эрчмийг сэнсний тусламжтайгаар механик энергид хувирган, худгаас ус татах шахуургыг ажиллуулахад зориулагдсан төхөөрөмжийг салхин ус өргүүр гэнэ.

## 4 Марк

4.1. Салхин ус өргүүрт СУӨ-3 , СУӨ-5, СУӨ-8 гэсэн марк хэрэглэнэ.

4.2. СУӨ-3, СУӨ-5, СУӨ-8 гэсэн маркны СУӨ-Салхин ус өргүүр, арын тоо- сэнсний голчийг м-ээр илэрхийлнэ.

**ЖИШЭЭ:** 3 метрийн голчтой сэнс бүхий усны бүлүүрт шахуургатай салхин ус өргүүрийг СУӨ- 3- Б гэж тэмдэглэнэ.

**5 Техникийн үзүүлэлт**

5.1. Салхин ус өргүүрийн техникийн үзүүлэлтийг 1-р хүснэгтэд үзүүлэв.

1-р хүснэгт

Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	СУӨ - 3Б	СУӨ-5Б	СУӨ-8Б
1	Сэнсний голч	м	3.0	5.0	8.0
2	Далбааны тоо	ш	12	24	24
3	Эхлэн ажиллах салхины хурд	м/с	3.0	3.0	3.0
4	Хэвийн хүчин чадлаар ажиллах салхины хурд	м/с	8.0	8.0	8.0
5	Салхины дээд хурд	м/с	40	40	40
6	8 м/ сек салхины хурданд Н=15 м гүнээс ус татах шахуургын бүтээмж	м <sup>3</sup> / цаг	2.8	4.2	6.1
7	Шахуургын төрөл	--	Бүлүүрт	Бүлүүрт	Бүлүүрт
8	Ус татах гүн	м	15	30	50
9	Тооцоот салхины хурданд эргэх сэнсний эргэлтийн тоо	эрг/мин	150	180	140
10	Сэнсийг салхинд чиглүүлэх механизм	--	Сүүлний систем	Сүүлний систем	Сүүлний систем
11	Цамхгийн өндөр	м	5.0	12	18
12	Жин	кг	420	1100	1700

**6 Техникийн шаардлага**

6.1. Энэ стандартын техникийн шаардлага, зохих горим, ажлын зургийн дагуу салхин ус өргүүрийг үйлдвэрлэнэ.

6.2. Салхин ус өргүүр нь 1-р хүснэгтэнд заасан үзүүлэлтүүдийг хангасан байх шаардлагатай.

6.3. Салхи ашиглалтын итгэлцүүр  $\xi_c$  нь удаан эргэлтийн олон далбаатай салхин ус өргүүрт 0.33-аас доошгүй байна.

- 6.4.** Бүх төрлийн салхин ус өргүүр нь сэнсний эргэлтийг тохируулах төхөөрөмж, сэнсийг чиглүүлэх сүүлний систем бүхий залууртай байна.
- 6.5.** Салхин агрегатын сэнсний эргэлтийг зогсоох гар удирдлагын төхөөрөмжтэй байна.
- 6.6.** Сэнсний тэнхлэг газрын гадаргуугаас 5 м - ээс доошгүй өндөрт байрлана.
- 6.7.** Усны шахуурга болон ус дамжуулах яндангийн гадна дотор гадаргуу нь хүнсний төхөөрөмжүүдэд тавигдах эрүүл ахуйн шаардлагыг хангасан байна.

## **7 Савлах, хаяглах**

- 7.1.** Редуктор болон багаж сэлбэг, холбогч хэрэгсэлийг техникийн тосоор тосолсон цаасанд ороож модон хайрцагт савласан байна.
- 7.2.** Бүтээгдэхүүнийг савласан хайрцганд дараах шошго зүүж, дурдсан бичиг баримтыг дагалдуулна.
- Шошгонд:
- үйлдвэрлэгчийн нэр
  - үйлдвэрлэсэн он, сар, өдөр
  - бүтээгдэхүүний нэр, төрөл, марк
  - эд шалгагчийн баталгаа
- Дагалдах бичиг баримтанд:
- техникийн гэрчилгээ
  - ашиглалтын заавар
  - чанарын баталгаа

## **8 Шалгах, турших, хүлээн авах**

- 8.1.** Сэнсний тэнцвэржүүлэлтийг хийсний дараа далбааг дугаарлаж будаг болон дардасаар тэмдэглэнэ.
- 8.2.** Сэнс болон шахуургын техникийн үзүүлэлтийг үйлдвэрийн нөхцөлд шалгаж, гэрчилгээгээр баталгаажуулна.
- 8.3.** Эд шалгагч нь СУӨ-ийн эд анги, угсаргааны нэгж ба иж бүрдлийг шалгаж, тэдгээрийн чанарт үнэлгээ өгч, тэмдэглэгээ хийсний дараа СУӨ-ийг хэрэглэгчид хүргэнэ.

## **9 Тээвэрлэх**

- 9.1.** СУӨ-ийн угсаргааны нэгж тус бүрийг хайрцганд савлаж, тээвэрлэнэ.

## **10 Хадгалах**

- 10.1.** Салхин ус өргүүрийг хадгалахдаа ХАА-н машин техник хадгалахад тавигдах техникийн шаардлагыг хангасан байна.

## **11 Угсрах**

- 11.1.** Ашиглалтын зааврын дагуу угсарна.

**ТӨГСӨВ.**

## А Хавсралт (үргэлжлэл)

### Монгол орны салхины эрчмийн нөөцийн карт

